



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр сарын 6-ны  
өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 126 “АЛТАНБУЛАГ”, “ЗАМЫН-ҮҮД”, “ЦАГААННУУР” ЧӨЛӨӨТ БҮСҮҮДИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Чөлөөт бүсийн тухай хуулийн 8.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас  
ТОГТООХ нь:

1. “Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур” чөлөөт бүсүүдийн Захирагчийн ажлын албаны бүтцийг дор дурдсанаар баталсугай:

а) “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба:

1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс; 2. Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтэс; 3. Гэрээ, эрх зүй, хүний нөөцийн хэлтэс; 4. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтэс; 5. Бүртгэл, санхүүгийн хэлтэс.

б) “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба:

1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс; 2. Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтэс; 3. Гэрээ, эрх зүй, хүний нөөцийн хэлтэс; 4. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтэс; 5. Бүртгэл, санхүүгийн хэлтэс.

в) “Цагааннуур” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба:

1. Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтэс; 2. Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтэс; 3. Захиргаа, аж ахуй, бүртгэлийн хэлтэс.

2. “Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур” чөлөөт бүсүүдийн Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг хавсралт ёсоор баталж, 2016 оны төсвийн жилээс эхлэн мөрдсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, тухайн бүсэд ажиллах мэргэжлийн хяналтын албаны бүтэц, орон тоог батлах тухай” Засгийн газрын 2002 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 227 дугаар тогтоол, “Орон тоо, зардлын хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 45 дугаар тогтоол, “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба байгуулах тухай” Засгийн газрын 2005 оны 6 дугаар сарын 15-ны

өдрийн 134 дүгээр тогтоол, “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны орон тоо болон зардлын хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2007 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоол, “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 227 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Аж үйлдвэрийн сайд

Д.ЭРДЭНЭБАТ

Засгийн газрын 2015 оны 126 дугаар

тогтоолын хавсралт

**“АЛТАНБУЛАГ”, “ЗАМЫН-ҮҮД”, “ЦАГААННУУР”  
ЧӨЛӨӨТ БҮСҮҮДИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ОРОН ТООНЫ ХЯЗГААР**

<b>№</b>	<b>Захирагчийн ажлын албаны нэр</b>	<b>Орон тооны хязгаар</b>
1	“Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба	42
2	“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба	41
3	“Цагааннуур” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба	23
<b>НИЙТ</b>		106

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 7 дугаар сарын 7-ны  
өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 291 ТОГТООЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Газрын төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Чөлөөт бүсийн тухай хуулийн 22.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 152 дугаар тогтоолд дор дурдсан агуулга бүхий 4 дүгээр хавсралт нэмсүгэй:

Засгийн газрын 1997 оны 152 дугаар

тогтоолын 4 дүгээр хавсралт

АЛТАНБУЛАГ, ЗАМЫН-ҮҮД, ЦАГААННУУРЫН ЧӨЛӨӨТ БҮСИЙН

1 ГА ГАЗРЫН СУУРЬ ҮНЭЛГЭЭ (төгрөгөөр)

№	Чөлөөт бүсийн нэр	1 га газрын суурь үнэлгээ (төгрөг) (газар ашиглалтын зориулалтаар)	
		Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	Хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэл
1	Алтанбулаг	120,000,000.0	80,000,000.0
2	Замын-Үүд	150,000,000.0	120,000,000.0
3	Цагааннуур	20,000,000.0	14,000,000.0

2. Чөлөөт бүсийн 1 га газрын төлбөрийн хязгаарыг түүний суурь үнэлгээний 1,0 хувь байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 152 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “3 дугаар хавсралтын ёсоор” гэсний дараа “Чөлөөт бүсийн 1 га газрын суурь үнэлгээ”-г 4 дүгээр хавсралтын ёсоор” гэж

нэмж, “Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн газрын төлбөрийн тухай” Засгийн газрын  
2006 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 169 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий  
сайд Ч.САЙХАНБИЛЭГ

Барилга, хот байгуулалтын сайд

Д.ЦОГТБААТАР



## **“Замын-Үүд ”эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг батлах тухай”**

2011 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

“Замын-Үүд ”эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг батлах тухай Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.6-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.”Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг хавсралтад заасан бүрдэлтэйгээр баталсугай.

2.”Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөнд заасан арга хэмжээ болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улс, орон нутгийн төсөвт тусган, гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт хамруулах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт даалгасугай.

3.”Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг Замын-Үүд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үндсэн шийдэлтэй уялдуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуягт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.Батболд

Монгол Улсын Тэргүүн шадар сайд

Н.Алтанхуяг

## **ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ, ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Газрын тухай хуулийн 33.1.2, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.6.2, 5.1.8.2-т заасны дагуу Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, түүнчлэн Газрын тухай хуулийн 44.4-т заасны дагуу гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газар ашиглуулах болон Чөлөөт бүсийн тухай хуулийн 22.4-т заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чөлөөт бүсэд газар эзэмших, ашиглах эрх олгох дуудлага худалдааг зохион байгуулахтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа (цаашид “дуудлага худалдаа” гэх)-г аймаг, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын болон чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн тухайн шатны Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч зохион байгуулна.

1.3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Иргэний хуулийн 84.3-т заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар хувьчилж байгаа тохиолдолд түүний дуудлага худалдааны анхны үнэд газар эзэмших эрхийн дуудлага худалдааны анхны үнийг оролцуулан тооцож, дуудлага худалдааг зохион байгуулна.

### **Хоёр. Дуудлага худалдаа явуулахад баримтлах зарчим**

2.1.Дуудлага худалдаа явуулахад дараах зарчмыг баримтална:

2.1.1.дуудлага худалдаанд оруулах газрыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн болон чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулахаар заасан байх;

2.1.2.үнийн саналаа ээлж дараалан тодорхой алхамтайгаар өсгөх;

2.1.3.нээлттэй, ил тод байх;

2.1.4.тэгш, шударга оролцоог хангасан байх.

**Гурав. Дуудлага худалдаагаар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын зориулалт**

3.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах тохиолдолд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулна:

3.1.1. Газрын тухай хуулийн 33.1.2-т заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах;

3.1.2. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.6.2, 5.1.8.2-т заасны дагуу газар өмчлүүлэх;

3.1.3. шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гаргасан албадан дуудлага худалдаа явуулах хүсэлтийн дагуу газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх;

3.1.4. газар өмчлөгч, эзэмшигчийн газар өмчлөх, эзэмших эрхээ дуудлага худалдаагаар худалдах хүсэлтийн дагуу газар өмчлөх, эзэмших эрхийг шилжүүлэх;

3.1.5. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, банк, банк бус санхүүгийн байгууллагаас гаргасан дуудлага худалдаа явуулах хүсэлтийн дагуу газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх;  
*(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмж, дугаарлалтыг өөрчилсөн)*

3.1.6. хуульд заасан бусад тохиолдолд.

3.2. “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-д зааснаас бусад тохиолдолд чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, ашиглах эрх олгох дуудлага худалдааг тухайн чөлөөт бүсийн захирагч зохион байгуулна.

### **Дөрөв. Дуудлага худалдаанд оролцогч, түүний эрх, үүрэг**

4.1. Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн хуульд заасан газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дагуу дуудлага худалдаанд оролцох хүсэлт гаргаж, дэнчин тавьснаар дуудлага худалдаанд оролцоно.

4.2. Дуудлага худалдаанд оролцогч дараах эрх эдэлнэ:

4.2.1. дуудлага худалдаагаар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын талаарх мэдээлэлтэй үнэ төлбөргүй танилцах;

4.2.2. дуудлага худалдаанд ялаагүй бол дэнчингээ буцааж авах;

4.2.3. дуудлага худалдаатай холбогдсон гомдлоо шүүхэд гаргах.

4.3. Дуудлага худалдаанд оролцогч дараах үүрэг хүлээнэ:

4.3.1.дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлж, дэнчингээ төлсөн байх;

4.3.2.дуудлага худалдааны дэг журмыг сахих;

4.3.3.дуудлага худалдаанд ялсан тохиолдолд дуудлага худалдааны үнийг энэ журмын 11.3-т заасан хугацаанд төлөх.

4.4.Дуудлага худалдаанд оролцогч нэг зөвлөхийн хамт оролцож болох бөгөөд зөвлөх пайз өргөх болон үнэ дуудах эрх эдлэхгүй.

4.5.Дуудлага худалдааны явцад оролцогч болон зөвлөх аливаа хэлбэрээр дуудлага худалдааг тасалдуулах үйл ажиллагаа явуулах, түүний дотор үнийн санал дуудах дарааллыг алдагдуулах, гар утсаар ярих, бусдад нөлөөлөх оролдлого хийхийг хориглоно.

4.6.Дуудлага худалдаанд худалдагч, оролцогчийн аль ч талыг төлөөлөөгүй хүнийг ажиглагч гэнэ.

4.7.Ажиглагч дуудлага худалдааны дэг журмыг чанд сахих үүрэгтэй.

4.8.Ажиглагч дуудлага худалдааны дэг журмыг зөрчвөл түүнийг дуудлага худалдаа явагдаж байгаа танхимаас гаргана.

**Тав. Дуудлага худалдааны хэлбэр, дуудлага худалдаа явуулах дараалал**

5.1.Дуудлага худалдааг дараах хэлбэрийн аль нэгээр явуулна:

5.1.1.танхимын;

5.1.2.цахим.

5.2.Дуудлага худалдааг дараах дарааллын дагуу явуулна:

5.2.1.дуудлага худалдааны бэлтгэл ажлыг хангах;

5.2.2.дуудлага худалдааг зарлан мэдээлэх;

5.2.3.дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх;

5.2.4.дуудлага худалдааг явуулах;

5.2.5.дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах.

5.3.Дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулах тохиолдолд Газрын биржийн цахим системээр зохион байгуулна. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

## **Зургаа. Дуудлага худалдааны бэлтгэл ажлыг хангах**

6.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын алба, сумын газрын даамал болон чөлөөт бүсийн захирагчийн Ажлын алба дуудлага худалдаа зохион байгуулахтай холбогдуулан дор дурдсан бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэнэ:

6.1.1. дуудлага худалдаагаар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах тухайн нэгж талбарын эргэлтийн цэгүүдийг тодорхойлон газар дээр нь тэмдэгжүүлэх;

6.1.2. дуудлага худалдааны тов, тухайн нэгж талбарын хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, дуудлага худалдааны хэлбэр, хугацаа, дэнчингийн хэмжээг тогтоосон шийдвэрийн төслийг бэлтгэж, тухайн шатны Засаг дарга, чөлөөт бүсийн захирагчаар гаргуулах;

6.1.3. шаардлагатай тохиолдолд тухайн нэгж талбар дээр барих барилга байгууламжийн техникийн нөхцөл, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулах.

6.2. Дуудлага худалдааны бэлтгэл ажлын зардлыг дуудлага худалдааны орлогоос гаргана.

6.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан дуудлага худалдааг хүсэлт гаргасан этгээдтэй газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан загварын дагуу гэрээ байгуулсны үндсэн дээр зохион байгуулна. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

6.4. Энэ журмын 6.3-т заасан дуудлага худалдаа явуулах зардлыг хүсэлт гаргасан этгээд хариуцна. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

## **Долоо. Дуудлага худалдааны зарыг зарлан мэдээлэх**

7.1. Дуудлага худалдааны зар (цаашид “зар” гэх)-ыг уг дуудлага худалдаа явуулахаар товлосон өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө дараах байдлаар нийтэд мэдээлнэ:

7.1.1. олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр;

7.1.2. аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, чөлөөт бүсийн захирагчийн албаны болон сумын нутгийн захиргааны байгууллагын цахим хуудсаар;

7.1.3. Газрын биржийн цахим системээр. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

7.2. Энэ журмын 7.1-д заасан зард дараах мэдээллийг заавал тусгана:

7.2.1. дуудлага худалдаагаар газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

7.2.2.дуудлага худалдааны хэлбэр;

7.2.3.газрын байршил, хил заагийг харуулсан зураг;

7.2.4.газрын талбайн хэмжээ;

7.2.5.дуудлага худалдааны анхны үнэ;

7.2.6.дэнчингийн хэмжээ, дэнчин тушаах дансны дугаар;

7.2.7.гэрээний зүйл;

7.2.8.дуудлага худалдаа явуулах газрын хаяг, харилцах утасны дугаар;

7.2.9.дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа;

7.2.10.дуудлага худалдаа эхлэх, дуусах он, сар, өдөр, цаг;

7.2.11.газар эзэмших, ашиглах зориулалт, хугацаа;

7.2.12.энэ журмын 6.1.3-т заасан тохиолдолд тухайн нэгж талбар дээр барих барилга байгууламжийн техникийн нөхцөлүүд болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийн талаарх ерөнхий мэдээлэл.

7.3.Дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулах тохиолдолд холбогдох цахим хуудасны мэдээлэл (дуудлага худалдаа явуулах Газрын биржийн цахим систем бүхий)-ийг зард тусгана. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)*

### **Найм. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх**

8.1.Танхимын хэлбэрээр явуулах дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг хүлээн авахад зориулсан бүртгэлийн хайрцгийг тухайн дуудлага худалдаа явагдахаас 3 хоногийн өмнө бэлтгэж битүүмжлэн тэмдэглэл үйлдэх бөгөөд бүртгэлийн хайрцгийг дуудлага худалдаа явуулахаар товлосон байранд байрлуулах, уг хайрцаг болон түүний лацны бүрэн бүтэн байдлыг тухайн дуудлага худалдаа явуулах Ажлын хэсэг хариуцна.

8.2.Дуудлага худалдаанд оролцохыг хүссэн этгээд хүсэлтээ энэ журмын 1, 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу үнэн зөв гаргана.

8.3.Дуудлага худалдаанд оролцогч дуудлага худалдаанд оролцох хүсэлтдээ дараах материалыг хавсаргаж, бүртгэлийн хайрцагт хийнэ:

8.3.1.иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримт, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

8.3.2.дэнчин төлсөн баримт;

8.3.3.дуудлага худалдаанд иргэнийг төлөөлж оролцох тохиолдолд тухайн иргэний олгосон нотариатчаар гэрчлүүлсэн итгэмжлэл;

8.3.4.дуудлага худалдаанд аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлж оролцох тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын олгосон итгэмжлэл.

8.4.Дуудлага худалдаа явуулах Ажлын хэсэг бүртгэлийн хайрцгийг дуудлага худалдаа явуулахаас 30 минутын өмнө хааж, дуудлага худалдаа эхлэх цаг болмогц лацыг шалган оролцогчдын өмнө задлах бөгөөд дуудлага худалдаанд оролцогчдын бичиг баримтын үнэн зөв эсэх болон дэнчин төлсөн байдлыг шалгаж, ирсэн хүсэлтүүдийг оролцогч тус бүрээр нь ялган тавьж бүртгэнэ.

8.5.Бүртгэлийн хайрцагт хийсэн материалаас ташаа мэдээлэл илэрсэн, эсхүл тухайн дуудлага худалдаанд оролцох хүсэлт биш тохиолдолд холбогдох этгээдийг дуудлага худалдаанд оролцуулахгүй.

8.6.Дуудлага худалдаанд оролцогчдын бүртгэл, мэдээллийг дуудлага худалдааг нээх хүртэлх хугацаанд нууцалж, бусдад энэ талаар мэдээлэл өгөхийг хориглоно.

8.7.Дуудлага худалдаанд оролцогч Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39.1.6-д заасан хураамжийг төлсөн байна.

### **Ес. Дуудлага худалдаа явуулах**

9.1.Тухайн шатны Засаг дарга болон чөлөөт бүсийн захирагч дуудлага худалдаа явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө дуудлага худалдаа явуулах Ажлын хэсгийг байгуулж ажиллуулна.

9.2.Дуудлага худалдаа явуулах Ажлын хэсэг нь дарга, дуудлага худалдааны хөтлөгч, тэмдэглэл хөтлөгч гэсэн бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь тухайн шатны Засаг даргын Тамгын газар болон чөлөөт бүсийн захирагчийн Ажлын албаны газрын асуудал хариуцсан албан тушаалтан буюу сумын газрын даамлыг оролцуулна.

9.3.Дуудлага худалдааны явцад үүссэн маргааныг тухайн дуудлага худалдаа явуулах Ажлын хэсэг хянан шийдвэрлэнэ.

9.4.Дуудлага худалдаа явуулах Ажлын хэсгийн дарга дор дурдсан эрх, үүрэгтэй:

9.4.1.дуудлага худалдаа явуулах ажлыг бүрэн хариуцах;

9.4.2.дуудлага худалдаа явуулахад оролцох туслах ажилтныг сонгон ажиллуулах;

9.4.3.дуудлага худалдааны явцын тэмдэглэл үнэн зөв, бүрэн хөтлөгдсөн эсэхийг хянаж баталгаажуулах.

9.5.Дуудлага худалдааны хөтлөгч дор дурдсан эрх, үүрэгтэй:

9.5.1.дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэж, хувийн дугаар бүхий пайз олгох;

9.5.2.дуудлага худалдааг товлосон газар, хугацаанд нь эхлүүлэх;

9.5.3.үнэ хаялцуулах дэгийн дарааллын талаар болон өсгөн хэлэх үнийн хэмжээг зарлаж танилцуулах;

9.5.4.дуудлага худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлүүлэх.

9.6.Дуудлага худалдааны тэмдэглэл хөтлөгч дор дурдсан эрх, үүрэгтэй:

9.6.1.дуудлага худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх;

9.6.2.дуудлага худалдааны явцын тэмдэглэлд оролцогчдоор гарын үсэг зуруулах.

9.7.Танхимын дуудлага худалдааг товлосон газарт дуудлага худалдаа эхлэх өдөр, цаг, минутад дараах дарааллаар явуулна:

9.7.1.дуудлага худалдаанд оролцогчдыг байраа эзлэхийг урих, оролцогч 3 дахь удаагаа урихад хүрэлцэн ирээгүй тохиолдолд түүнийг дуудлага худалдаанд оролцохоос татгалзсанд тооцож, энэ тухай тэмдэглэлд тусгана;

9.7.2.бүртгэлийн ажиллагаа дууссаны дараа дуудлага худалдаа явуулах Ажлын хэсгийн дарга оролцогчдод тухайн шатны Засаг дарга болон чөлөөт бүсийн захирагчийн дуудлага худалдаа явуулах захирамж, түүнтэй адилтгах шийдвэрийг уншиж сонгоно;

9.7.3.дуудлага худалдаа явуулах Ажлын хэсэг оролцогчдын биеийн байцаалтыг шалгасны дараа энэ журмын 3 дугаар хавсралтад заасан пайзыг хуваарилж олгоно;

9.7.4.хөтлөгч оролцогчдод дуудлага худалдааны журам болон үнэ хаялцуулах дэг, анхааруулах бусад зүйлийг танилцуулна;

9.7.5.хөтлөгч дуудлага худалдаанд оруулсан газрын талаар товч танилцуулж, дуудлага худалдааны өсгөн хэлэх үнийн хэмжээг дор дурдсан хүснэгтийн дагуу зарлан, дуудлага худалдаа эхлүүлнэ:

Өсгөн хэлэх үнийн хэмжээ

Хүснэгт 1

№	Дуудлага худалдааны анхны үнэ (төгрөг)	Өсгөн хэлэх үнэ (төгрөг)
1.	1 000 000 хүртэл	50 мянга-100 мянга
2.	1 000 001-5 000 000	100 мянга-500 мянга
3.	5 000 001-10 000 000	500 мянга-1 сая
4.	10 000 001-50 000 000	1 сая-5 сая
5.	50 000 001-100 000 000	5 сая- 10 сая
6.	100 000 001-500 000 000	10 сая-50 сая
7.	500 000 001-1 000 000 000	50 сая-100 сая
8.	1 000 000 001-5 000 000 000	100 сая-500 сая

9.7.6.оролцогч үнийн санал хэлэхэд хөтлөгч тухайн үнийн саналыг 3 удаа давтаж хэлнэ;

9.7.7.бусад оролцогчид энэ журмын 9.7.6-д зааснаас дээш үнийн санал хэлээгүй тохиолдолд хөтлөгч “буулаа” гэж хэлээд “нэг”, “хоёр”, “гурав” гэж тоолсны дараа дуут дохио өгч ялагчийг зарлаж, дуудлага худалдаа хаасныг мэдэгдэнэ;

9.7.8.дуудлага худалдаанд оролцогчид дуудлага худалдааны тэмдэглэлд гарын үсэг зурна.

9.8.Шаардлагатай тохиолдолд дуудлага худалдааны явцын талаар бүрэн дүрс бичлэг хийнэ.

9.9.Цахим дуудлага худалдааг дуудлага худалдаа эхлэх өдөр, цаг, минутад дараах дарааллаар явуулна:

9.9.1.тухайн шатны Засаг даргын Тамгын газар болон чөлөөт бүсийн захирагчийн Ажлын албаны цахим хуудсанд байршуулсан дуудлага худалдаа явуулах Газрын биржийн цахим системийг ашиглан цахим дуудлага худалдааг явуулна; *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)*

9.9.2.цахим дуудлага худалдаанд оролцохыг хүссэн этгээд дуудлага худалдааны зард заасан хугацаанд энэ журмын 8.3-т заасан материалыг бүрдүүлж, цахим хуудсанд хандан хүсэлтээ гаргана;

9.9.3.хүсэлтийг хүлээн авч, дуудлага худалдааны оролцогч болсныг цахим дуудлага худалдаа явуулах Газрын биржийн цахим системд нэвтрэх нэр, нууц үгээр баталгаажуулж оролцогчид мэдэгдэнэ; *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)*

9.9.4. цахим дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг цахим дуудлага худалдаа явагдахаас ажлын 5 хоногийн өмнөөс хүлээн авч эхлэн дуудлага худалдаа явагдах

өдрийн өмнөх өдрийн 15 цаг 00 минутад зогсоож, бүртгэлийг хаана; *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)*

9.9.5.дуудлага худалдаанд оролцогч өөрийн үнийн саналаа дуудлага худалдаа явуулах тусгай программ хангамжид байршуулах бөгөөд дуудлага худалдааг зөгөөх хүртэлх хугацаанд нэвтрэх, бусад оролцогчдоос ирүүлсэн үнийн саналтай танилцах, үнийн саналаа өөрчлөх эрхтэй; *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)*

9.9.6. цахим дуудлага худалдааг товлосон өдрийн 09 цаг 00 минут 00 секундэд эхлүүлж, мөн өдрийн 17 цаг 00 минут 00 секунд хүртэл явуулах бөгөөд дараахь байдлаар зохион байгуулна: *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)*

9.9.6.1.Цахим дуудлага худалдааны эхлэх, дуусах цагийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын цагаар тооцно; *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

9.9.6.2.Цахим дуудлага худалдаа 09 цаг 00 минутаас эхэлснээс хойш 15 цаг 00 минут хүртэл үнийн саналыг хүлээн авах бөгөөд 15 цаг 00 минутаас эхлэн үнэ хаялцуулах өрсөлдөөнийг эхлүүлнэ. Үнэ хаялцуулах өрсөлдөөнийг 60 секундээр тооцож явуулах бөгөөд уг хугацаанд оролцогчид үнийн саналаа өсгөх байдлаар өрсөлдөнө; *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

9.9.6.3.Үнэ хаялцуулах өрсөлдөөний 60 секундийн хугацаа дуусч, дараагийн 60 секунд тоологдож эхлээд оролцогчдоос үнийн саналыг өсгөн өгөөгүй тохиолдолд хамгийн их дүнтэй үнийн санал өгсөн оролцогчийг ялагчаар тодруулан цахим дуудлага худалдаа дууссан болохыг бүх оролцогчдод мэдэгдэнэ. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

9.9.7.энэ журмын 9.9.6-д заасан хугацаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчийг дуудлага худалдаа явуулах Газрын биржийн цахим систем ашиглан ялагчаар тодруулж, энэ тухай оролцогч тус бүрт мэдэгдэнэ; *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)*

9.9.8.дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаа явагдсан өдрөөс хойш 7 хоногийн дотор Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй;

9.9.9.цахим дуудлага худалдааг энэ журмын 9.9.6-д заасан хугацаанд зогсоосноор оролцогчдоос ирүүлсэн үнийн санал тус бүрийн хугацааг цаг, минут, секундээр бүртгэн тэмдэглэл хөтлөх бөгөөд түүнд Ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна;

9.9.10.дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын дэнчинг энэ журмын 12.3-т заасан хугацаанд буцаан шилжүүлэх бөгөөд шилжүүлэх данс тодорхойгүй тохиолдолд цахим бүртгэл дэх утас, хаягаар оролцогчтой холбогдож шилжүүлнэ;

9.9.11.дуудлага худалдааны үр дүнгийн талаарх мэдээллийг уг дуудлага худалдааг зохион байгуулснаас хойш хуанлийн 3 өдрийн дотор интернэтээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ;

9.9.12.Байгалийн давагдашгүй хүчин зүйл гарсан, эсхүл програм хангамж, техникийн саатал, цахилгаан эрчим хүч, сүлжээ тасарч доголдсоноос цахим дуудлага худалдаа хэвийн явагдах боломжгүй болсон тохиолдолд тухайн дуудлага худалдааг хүчингүйд тооцож, ажлын 5 хоногийн дотор давтан зохион байгуулна. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

9.10.Дуудлага худалдаа явуулахтай холбогдсон энэ журмаар зохицуулаагүй харилцааг Иргэний хуулийн 197 дугаар зүйл болон Газрын тухай хуулийн 18.1.4-т заасан газрын биржийн журамд заасны дагуу зохицуулна.

9.11.Дуудлага худалдаанд 1 оролцогч ирсэн, эсхүл дуудлага худалдааны анхны үнээс дээш үнийн санал гаргаагүй бол дуудлага худалдаа явагдаагүй гэж үзнэ.

### **Арав. Дуудлага худалдааг дахин явуулах**

10.1.Дараах тохиолдолд дуудлага худалдааг дахин явуулна:

10.1.1.дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаагаар худалдан авсан газрын болон газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний үнийг энэ журмын 11.3-т заасан хугацаанд бүрэн төлөөгүй, эсхүл төлөхийг зөвшөөрөөгүй тохиолдолд;

10.1.2.дуудлага худалдаа явагдаагүй болон явуулах нөхцөл бүрдээгүй;

10.1.3.хууль зөрчин явуулсныг шүүхийн шийдвэрээр тогтоосон;

10.1.4.Дуудлага худалдааны ялагч энэ журмын 11.2-т заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд; *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмж, дугаарлалтыг өөрчилсөн)*

10.1.5.хуульд заасан бусад тохиолдолд.

10.2.Дуудлага худалдааг дахин явуулах шийдвэрийг тухайн шатны Засаг дарга буюу чөлөөт бүсийн захирагч гаргах бөгөөд дуудлага худалдааны зарыг дахин дуудлага худалдаа явуулах өдрөөс хуанлийн 14-өөс доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

10.3.Дуудлага худалдааг дахин явуулахдаа энэ журмыг мөрдөнө.

10.4.Энэ журмын 10.1-д заасан дуудлага худалдаанд 1 оролцогч оролцох хүсэлт гаргасан тохиолдолд дуудлага худалдааны анхны үнэ дээр өсгөн хэлэх үнийн доод хэмжээг нэмж, дуудлага худалдаагаар худалдан авах үнийг тогтоох бөгөөд тухайн оролцогч зөвшөөрвөл түүнийг дуудлага худалдааны ялагч гэж үзнэ.

### **Арван нэг. Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах**

11.1.Дуудлага худалдаанд оролцогчдоос хамгийн өндөр үнийн санал хэлсэн оролцогч тухайн дуудлага худалдааны ялагч болно.

11.2.Дуудлага худалдаа явагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор дуудлага худалдааны тэмдэглэлийг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамал болон чөлөөт бүсийн захирагчийн Ажлын алба дуудлага худалдааны ялагчтай Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулна. Гэрээнд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

11.2.1.дуудлага худалдаагаар худалдан авсан газрын байршил, зориулалт;

11.2.2.талбайн хэмжээ;

11.2.3.дуудлага худалдаанд оролцоход тавьсан дэнчингийн хэмжээ;

11.2.4.дуудлага худалдаагаар худалдан авсан үнэ болон газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний үнэ, түүнийг төлөх хэлбэр, хугацаа.

11.3.Дуудлага худалдааны ялагч гэрээ байгуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор энэ журмын 11.2-т заасан дуудлага худалдааны үнийг бүрэн төлнө.

11.4.Дуудлага худалдааны ялагч энэ журмын 11.3-т заасан хугацаанд дуудлага худалдааны үнийг бүрэн төлснөөр тухайн шатны Засаг дарга газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, Чөлөөт бүсийн захирагч газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай шийдвэр гаргана.

11.5.Энэ журмын 11.4-т заасан шийдвэрийг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамал, чөлөөт бүсийн захирагчийн Ажлын алба холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу дуудлага худалдааны ялагчтай газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ байгуулж гэрчилгээ олгох бөгөөд ажлын 21 хоногт багтаан газрыг зохих ёсоор өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид нь хүлээлгэн өгнө.

11.6.Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах гэрээний нөхцөлд тухайн газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд заасны дагуу ашиглахтай холбогдсон зураг төслийг 6 сарын дотор багтаан боловсруулж ирүүлэхээр тусгана.

11.7.Дуудлага худалдаа явагдсан газрын нэгж талбар бүрт хувийн хэрэг нээж, холбогдох баримт бичгүүдийн хамт архивт хадгална.

11.8. Дуудлага худалдааны ялагч энэ журмын 11.3-т заасан хугацаанд дуудлага худалдааны үнийг бүрэн төлснөөр өөрийн газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ бусад этгээдэд шилжүүлж болох бөгөөд шилжүүлэн авах этгээд нь ялагчийн эрх, үүрэг, хариуцлагыг хүлээн зөвшөөрч байгааг бичгээр нотолсон байна.

11.9. Дуудлага худалдааны ялагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ журмын 11.2, 11.3-т тус тус заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, эсхүл дуудлага худалдааны үнийг бүрэн төлөөгүй тохиолдолд тухайн дуудлага худалдааг хүчингүйд тооцно. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

11.10. Дуудлага худалдааны ялагчид хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн тохиолдолд энэ журмын 11.2, 11.3-т тус тус заасан хугацааг ажлын 5 хоногоор тус бүр сунгаж болно. Энэ тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгааныг Татварын ерөнхий хуулийн 6.1.41-д зааснаар ойлгоно. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

11.11. Дуудлага худалдааны ялагч хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн тохиолдолд дуудлага худалдаа явуулах Ажлын хэсэгт заавал мэдэгдэх бөгөөд мэдэгдээгүй тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаан үүссэнд тооцохгүй. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

### **Арван хоёр. Дуудлага худалдааны үнэ, дэнчин**

12.1. Дуудлага худалдааны анхны үнийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлалын дагуу тухайн шатны Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч тогтоох бөгөөд дэнчингийн хэмжээ нь дуудлага худалдааны анхны үнийн дүнгийн 10 хувьтай тэнцүү байна.

12.2. Аймаг, нийслэл, чөлөөт бүс тус бүр төрийн сангийн газрын биржийн тусгай данстай байх бөгөөд уг дансанд дуудлага худалдааны орлого, дэнчинг төвлөрүүлнэ. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)*

12.3. Дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын дэнчинг дуудлага худалдаа болсон өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор аливаа шимтгэлгүйгээр буцаан олгоно.

12.4. Дуудлага худалдаанд оролцоход тавьсан дэнчинг дуудлага худалдааны үнийн гүйцэтгэлд оролцуулан тооцно.

12.5. Дуудлага худалдааны ялагч нь гэрээ байгуулж, дуудлага худалдааны үнийг энэ журмын 11.3-т заасан хугацаанд төлөөгүй бол уг газрыг дахин дуудлага худалдаанд оруулж, дэнчинг улсын орлого болгоно.

### **Арван гурав. Дуудлага худалдааны орлогыг тайлагнах, зарцуулах**

13.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нь тухайн жилд явуулсан дуудлага худалдааны тайланг орлого, зарцуулалтын тайлангийн хамт чөлөөт бүсийн

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлнэ.

13.2. Дуудлага худалдааны орлогоос газар зохион байгуулалтын болон бэлчээрийн менежмент хийх, газрыг хамгаалах, нөхөн сэргээх, дуудлага худалдаа явуулах, програм хангамжийг хөгжүүлэх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, албан хаагчдыг чадавхжуулах арга хэмжээнд зарцуулна. (Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмэлт орсон)

13.3. Аймаг, нийслэлийн Газрын алба болон чөлөөт бүсийн захирагчийн Ажлын алба нь тухайн жилд явуулсан дуудлага худалдааны тайланг сум, дүүрэг тус бүрээр нэгтгэн хагас жилийн тайланг дараа сарын 15-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны эхний сарын 15-ны өдрийн дотор тус тус газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

13.4. Энэ журмын 13.2-т заасан арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн улсын төсөвт тусгаж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр зарцуулна. (Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)

#### **Арван дөрөв. Бусад**

14.1. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх дуудлага худалдааны анхны үнийг Засгийн газрын 2003 оны 103 дугаар тогтоолоор баталсан “Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлал”-ын дагуу тогтооно.

14.2. Энэ журмын 9.1-д заасан дуудлага худалдаа явуулах Ажлын хэсгийн гишүүд хараат бус, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, дуудлага худалдааны мэдээллийг задруулах, бусдад давуу байдал олгох аливаа үйлдэл хийхийг хориглоно. (Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)

#### **Арван тав. Маргаан шийдвэрлэх**

15.1. Дуудлага худалдааны явцад үүссэн маргааныг дуудлага худалдаа явуулах Ажлын хэсэг шийдвэрлэнэ.

15.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дуудлага худалдаатай холбогдсон гомдлоо тухайн шатны Засаг дарга болон чөлөөт бүсийн захирагч, шүүхэд тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журмын 1 дүгээр хавсралт

## ДУУДЛАГА ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ

(Хувь хүн)

... он ... сар ... өдөр

ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	
1.Иргэний харьяалал .....	3.Эцэг (эх)-ийн нэр .....
.....	.....
2.Овог .....	4.Нэр .....
.....	.....
5.Регистрийн дугаар .....	6.Холбоо барих утас .....
.....	.....
7.Шуудангийн хаяг .....	8.Цахим шуудангийн хаяг .....
.....	.....
9.Байнгын оршин суугаа хаяг ..... аймаг (нийслэл), ..... сум (дүүрэг) ..... баг (хороо) ..... гудамж (хороолол) ..... байр (хашаа, хаалга)-ны дугаар	

**ЗӨВЛӨХИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

1.Овог .....	4.Регистрийн дугаар .....
2.Эцэг (эх)-ийн нэр .....	5.Холбоо барих утас .....
3.Нэр .....	

**НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ**

1.Газрын зориулалт .....	2.Тухайн газрыг өмчлөх, эзэмших, ашиглахын аль нь болох .....
3.Талбайн хэмжээ (м <sup>2</sup> /га) .....	4.Эзэмших, ашиглах хугацаа .....
5.Газрын байршлын хаяг ..... аймаг (нийслэл), ..... сум (дүүрэг) ..... баг (хороо) ..... гудамж (хороолол) ..... байр (хашаа, хаалга)-ны дугаар ..... байршлын нэр	

**ДЭНЧИНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

1.Дэнчингийн хэмжээ (төг) ..... (тоогоор) .....	2.Дэнчин төлсөн огноо .....
(үсгээр) .....	

ӨРГӨДӨЛ ГАРГАСАН (.....)

Нэрийг бүтнээр бичнэ

*Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журмын 2 дугаар хавсралт*

**ДУУДЛАГА ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ**

(Хуулийн этгээд)

... он ... сар ... өдөр

ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН Т	
1.Оноосон нэр .....	
2.Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар .....	3.Регистрийн
.....	.....
4.Холбоо барих утас .....	5.Шуудангийн
.....	.....
6.Хаяг ..... аймаг (нийслэл), ..... сум (дүүрэг) .....	
..... байр (хашаа, хаалга)-ны дугаар .....	
7.Цахим шуудангийн хаяг .....	
ОРОЛЦОГЧИЙН ТАЛА	
1.Иргэний харьяалал .....	3.Эцэг (эх)-ий
.....	.....

2.Овог .....	4.Нэр .....
5.Регистрийн дугаар .....	6.Холбоо бар
7.Албан тушаал .....	8.Цахим шууд
9.Байнгын оршин суугаа хаяг ..... аймаг (нийслэл), ..... гудамж (хороолол) .....	

**ЗӨВЛӨХИЙН ТАЛАА**

1.Овог .....	
2.Эцэг (эх)-ийн нэр .....	4.Регистрийн
3.Нэр .....	5.Холбоо бар

**НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ**

1.Газрын зориулалт .....	2.Тухайн газр
3.Талбайн хэмжээ (м <sup>2</sup> /га) .....	4.Эзэмших, ал

5.Газрын байршлын хаяг ..... аймаг (нийслэл), .....  
гудамж (хороолол) ..... байр (хашаа, хаалга)-ны дугаар .....

.....

ДЭНЧИНГИЙН ТАЛА

1.Дэнчингийн хэмжээ (төг) ..... (тоогоор)

.....

(үсгээр) .....

2.Дэнчин төл

.....

ӨРГӨДӨЛ ГАРГАСАН (.....)

Нэрийг бүтнээр бичнэ



## **ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Газрын тухай хуулийн 33.1.2, Чөлөөт бүсийн тухай хуулийн 22.4, Концессын тухай хуулийн 2.5-д тус тус заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт (цаашид “төсөл сонгон шалгаруулалт” гэх)-ыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл шалгаруулалтыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын болон чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн тухайн шатны Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч зохион байгуулна.

1.3.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“төсөл сонгон шалгаруулалт” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг төсөл сонгон шалгаруулах зарчмаар зохион байгуулахыг;

1.3.2.“ажлын хэсэг” гэж төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий 5 буюу түүнээс дээш сондгой тооны бүрэлдэхүүнтэй багийг;

1.3.3.“төсөл” гэж “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS ISO 21500 стандартын дагуу боловсруулагдсан цогц баримт бичгийг;

1.3.4.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай газар” гэж газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх болон хөдөө аж ахуйн зориулалттай барилга байгууламж барих газрыг.

1.4.Концессын зүйл нь газрын бүрдэл хэсэг бол тухайн газрыг эзэмшүүлэх, ашиглуулахад энэ журмыг мөрдөнө.

1.5.Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг Газрын биржийн цахим системээр зохион байгуулж болно. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

**Хоёр. Төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад баримтлах зарчим**

2.1.Төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулахад дараах зарчмыг баримтална:

2.1.1.тэгш, шударга оролцоог хангасан байх;

2.1.2.хамгийн өндөр оноо авсан төслийг сонгон шалгаруулах;

2.1.3.төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах газрыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын болон чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд эзэмшүүлэх, ашиглуулахаар заасан байх.

### **Гурав. Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах газар**

3.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зориулж газрыг төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлж, ашиглуулна. (Энэ заалтыг Засгийн газрын 2019 оны 105 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

3.2.Гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр нь Олон улсын гэрээний тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлаас соёрхон баталсан, эсхүл Засгийн газрын байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрээр баталгаажсан байна. (Энэ заалтыг Засгийн газрын 2019 оны 105 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

### **Дөрөв. Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчид тавих шаардлага**

4.1.Төсөл сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирүүлсэн этгээд дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1.хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвартай байх;

4.1.2.мэргэжлийн ажиллах хүчний болон техник технологи, тоног төхөөрөмжийн чадавх, нөөцтэй байх;

4.1.3.төсөл нь зарласан нөхцөл шаардлага, стандартыг хангасан байх;

4.1.4.төслөө зарласан хугацаанд ирүүлсэн байх;

4.1.5.шаардлагатай тохиолдолд холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан байх.

4.2.Энэ журмын 4.1-д заасан этгээд нь төсөл сонгон шалгаруулалтад оролцохоор бүрдүүлсэн мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

### **Тав. Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааны дараалал**

5.1.Төсөл сонгон шалгаруулалтыг дараах дарааллын дагуу явуулна:

5.1.1.төсөл сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангах;

5.1.2.төсөл сонгон шалгаруулалтыг зарлан мэдээлэх;

5.1.3.төслийг хүлээн авах;

5.1.4.төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

5.1.5.шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах.

### **Зургаа. Төсөл сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангах**

6.1.Аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамал, чөлөөт бүсийн захирагчийн Ажлын алба нь төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулахтай холбогдуулан дор дурдсан бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэнэ:

6.1.1.төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын эргэлтийн цэгүүдийн солбицлыг газар дээр нь тодорхойлж тэмдэгжүүлэх;

6.1.2.тухайн газар дээр барилга байгууламж барих болон үйл ажиллагаа явуулахад шаардагдах мэргэжлийн байгууллагын дүгнэлт, техникийн нөхцөлүүдийг гаргуулах;

6.1.3.газрыг төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах тухай Засаг даргын болон чөлөөт бүсийн захирагчийн шийдвэр гарсан байх.

### **Долоо. Төсөл сонгон шалгаруулалтыг зарлан мэдээлэх**

7.1.Төсөл сонгон шалгаруулалтын зар (цаашид “зар” гэх)-ыг уг ажиллагааг явуулахаар товлосон өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө дараах байдлаар нийтэд мэдээлнэ:

7.1.1.олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр;

7.1.2.аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба болон чөлөөт бүсийн захирагчийн Ажлын албаны болон сумын нутгийн захиргааны байгууллагын цахим хуудсаар.

7.1.3.Газрын биржийн цахим системээр. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор нэмсэн)*

7.2.Энэ журмын 7.1-д заасан зард дараах мэдээллийг заавал тусгана:

7.2.1.төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

7.2.2.төслийг хүлээн авах газрын хаяг, харилцах утасны дугаар;

7.2.3.төслийг ирүүлэх хугацаа;

7.2.4.газар ашиглалтын зориулалт;

7.2.5.газрын талбайн хэмжээ;

7.2.6.газар эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа;

7.2.7.газрын байршил, хилийн заагийг харуулсан зураг;

7.2.8.мэргэжлийн байгууллагын дүгнэлт, техникийн нөхцөлийн талаарх ерөнхий мэдээлэл;

7.2.9.барилгын ажил эхлэх, дуусах хугацаа;

7.2.10.барилга байгууламжийн архитектур, төлөвлөлтийн шаардлага;

7.2.11.барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөө, тохижилтод тавих шаардлага.

7.3.Тухайн газрын онцлог, шинж чанараас шалтгаалан нэмэлт шаардлага тавьж болох бөгөөд түүнийг төсөл сонгон шалгаруулалтын зард заавал тусгана.

7.4.Тухайн газар дээр Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагаа эрхлэх бол энэ тухай зар мэдээнд тусгайлан заавал заасан байна.

### **Найм. Төслийг хүлээн авах**

8.1.Оролцогч нь битүүмжилсэн төслөө аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамалд, эсхүл чөлөөт бүсийн захирагчийн Ажлын албанд өөрөө буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр биечлэн хүргүүлэх, хэрэв ийнхүү хүргүүлэх боломжгүй бол зар мэдээнд заасан хугацаанд шуудангаар хүргүүлж болно.

8.2.Аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамал, чөлөөт бүсийн захирагчийн Ажлын алба төслийг зард заасан хугацаанд хүлээн авч, дор дурдсаны дагуу бүртгэнэ:

8.2.1.төслүүдийг ирүүлсэн дарааллын дагуу он, сар, өдөр, цаг, минутаар нь тэмдэглэн бүртгэж, тусгай тэмдэглэл үйлдэн архивын нэгж үүсгэн хадгална;

8.2.2.зард заасан хугацаа дууссаны дараа ирүүлсэн төслүүдэд хоцорсон тухай тусгай тэмдэглэл үйлдэн, тэмдэг дарна.

8.3.Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39.1.6-д заасан хураамжийг төлнө.

8.4.Аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамал, чөлөөт бүсийн захирагчийн Ажлын алба нь төсөл сонгон шалгаруулалттай холбогдсон нууцыг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

8.5.Төслийг тусгай программ хангамж бүхий Газрын биржийн цахим системээр хүлээн авч болно. *(Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)*

